# НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 12 сарын 24 өдөр Дугаар А/362 Улаанбаатар хот

Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох, тусгай зөвшөөрөлд чиглэл нэмэх, хүчингүй болгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн Зургадугаар бүлгийн 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 19.3.1, 19.3.4, 19.5.3, 19.21, 19.23 дахь хэсэг, Эрүүл мэндийн газрын дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 2/1126 дугаартай чиглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн хуулийн этгээдүүдийг 2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн газрын даргын зөвлөлийн хуралын шийдвэрээр Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох 13 хуулийн этгээдийн жагсаалтыг нэгдүгээр, тусгай зөвшөөрөлд чиглэл нэмэх 1 хуулийн этгээдийг хоёрдугаар, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох 1 хуулийн хуулийн этгээдийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хууль тогтоомж, стандартад нийцүүлэн үзүүлж, эмч, мэргэжилтний чадавхийг сайжруулан, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллахыг хуулийн этгээдэд үүрэг болгосугай.

3.Энэхүү тушаалын нэгдүгээр хавсралтад заасан эрүүл мэндийн байгууллагад эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээг холбогдох хууль тогтоомжийн дагуу олгож, харьяа дүүргийн татварын байгууллагад мэдэгдэн, мэдээллийг цахим хуудаст байршуулахыг Тусгай зөвшөөрөл хариуцсан мэргэжилтэн (Т.Жаргал)-д үүрэг болгосугай.

4.Тусгай зөвшөөрөл авснаас хойш үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн хэлтэс (Б.Батцоож)-д, тайлан, мэдээг хууль, журмын дагуу хүлээн авч нэгтгэн, дүн шинжилгээ хийх, шинээр тусгай зөвшөөрөл олгогдсон эрүүл мэндийн байгууллагын мэдээллийг газрын тайлан мэдээний санд оруулж, баяжуулалт хийн ажиллахыг Хяналт- шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс (Д.Сайнхүү)-д тус тус даалгасугай.

5.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, нэгдсэн удирдлагын хэлтсийн дарга (У.Бат-Очир)-д үүрэг болгосугай.

ДАРГА Н.НАРАНБААТАР

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын
2025 оны 12 дугаар сарын 24 -ны өдрийн
А/362 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

## ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ШИНЭЭР ОЛГОХ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЖАГСААЛТ

| д/д | Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн нэр /Регистрийн дугаар/ | Тусгай зөвшөөрлийн төрөл | Тусгай зөвшөөрлөөр эзэмших үйлчилгээний чиглэл | Хаяг |
|---|---|---|---|---|
| 1. | Ачиттун ХХК /5025133/ | Эмийн сан | Хоёрдугаар зэрэглэлийн эмийн сан | Баянзүрх дүүргийн 27дугаар хороо, Сэлбэ 6 гудамж, 134 тоот |
| 2. | Шилийн шонхор ХХК /5590418/ | Эмийн сан | Хоёрдугаар зэрэглэлийн эмийн сан | Баянзүрх дүүргийн 14дүгээр хороо, 14дүгээр хороолол, 90Д байр, 6 тоот |
| 3. | Од аюур фарм трейдинг ХХК /7144025/ | Эмийн сан | Хоёрдугаар зэрэглэлийн эмийн сан | Сонгинохайрхан дүүргийн , 41дүгээр хороо, Зээлийн 1А-1 |
| 4. | Агь анир ХХК /7114481/ | Клиник | Хүүхдийн өвчний тусламж, үйлчилгээ | Хан-Уул дүүргийн 11дүгээр хороо, Дунжингаравын гудамж, 204дүгээр байр, 4 тоот |
| 5. | Лью сиел мед ХХК /7079601/ | Клиник | УАУ-ны тусламж, үйлчилгээ | Баянгол дүүргийн, 18дугаар хороо, Нико центр, 2 давхарт |
| 6. | СЕГИМЕД ХХК /5522692/ | Клиник | Дотрын өвчний тусламж, үйлчилгээ | Баянзүрх дүүргийн , 43дугаар хороо, 13дугаар хороолол, Нарны зам гудамж, 101дүгээр байр, 3дугаар давхарт |
| 7. | Даймонд харвест ХХК /7123289/ | Клиник | Арьсны өвчний тусламж, үйлчилгээ нөхөн сэргээх мэс засал | Сүхбаатар дүүргийн, 1дүгээр хороо, Жамьянгүний гудамж, 10дугаар байр, 101 тоот |
| 8. | Чуулга өлзий ХХК /6114946/ | Клиник | Шүдний өвчний тусламж, үйлчилгээ / нүүр амны өвчний согог засал, нүүр амны өвчний мэс засал/ | Баянзүрх дүүргийн, 43дугаар хороо, 13дугаар хороолол, /13374/ нарны зам гудамж, 82 дугаар байр 13 тоот (Маргад хотхон) |
| 9. | Титан имплант клиник ХХК /8468028/ | Клиник | Шүдний өвчний тусламж, үйлчилгээ / нүүр амны өвчний согог засал, гажиг засал, нүүр амны мэс засал/ | Баянзүрх дүүргийн, 3дугаар хороо, “Сансар гарден” хотхоны 107 дугаар байр үйлчилгээний Ү-103 тоот |
| 10. | Эхлэл эрдэнэ ХХК /7108097/ | Клиник | Ахуйн хортон шавьж, мэрэгч устгал, халдваргүйжүүлэлтийн үйлчилгээ | Сүхбаатар дүүргийн, 10дугаар хороо, 7дугаар хороолол, Их тойруу Вива центр 2 давхарт, 206 тоот |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 11. | Хил хамгаалах ерөнхий газар | Клиник | Сэргээн засах тусламж, үйлчилгээ, уламжлалт анагаах ухааны өвчний тусламж, үйлчилгээ | Хан-Уул дүүргийн, 14дүгээр хороо, Бугын сангийн аж ахуй “Алтан шонхор” сэргээн засах төв |
| 12. | Шаргалжуут лайфстайл мед ХХК /8449031/ | Клиник | Дотрын, Мэдрэлийн өвчин, Уламжлалт анагаах ухааны өвчний тусламж, үйлчилгээ | Баянзүрх дүүргийн, 26дугаар хороо, Уранган Южи арена төвийн 2 давхарт |
| 13. | Амибат перфект дент ХХК /7140185/ | Клиник | Шүдний өвчний тусламж, үйлчилгээ / нүүр амны өвчний согог засал/ | Баянзүрх дүүргийн, 14дүгээр хороо, 14дүгээр хороолол, 9дүгээр байр, 174 тоот |

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын
2025 оны 12 дугаар сарын 24 -ны өдрийн
А/362 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

## ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛД ЧИГЛЭЛ НЭМЭХ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЖАГСААЛТ

| д/д | Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн нэр /регистрийн дугаар/ | Тусгай зөвшөөрлийн төрөл | Одоо эрхэлж буй үйл ажиллагааны төрөл | Тусгай зөвшөөрөлд нэмэх чиглэл |
|---|---|---|---|---|
| 1. | Хавана Пи Эс ХХК /6885586/ | Клиник | Шүдний өвчний оношилгоо, эмчилгээ, согог, гажиг засал | Нөхөн сэргээх пластик мэс засал, нүүр амны өвчний мэс засал |

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын
2025 оны 12 дугаар сарын 24 -ны өдрийн
А/362 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ
ХУУЛИЙН ЭТГЭЭД

| д/д | Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн нэр /регистрийн дугаар/ | Үйл ажиллагааны чиглэл | Тусгай зөвшөөрлийн дугаар | Үндэслэл |
|---|---|---|---|---|
| 1. | Хос төгс билэг ХХК /6197515/ | Эмийн сан | ЭСХ-17/22/3547 | Зөвшөөрлийн тухай хуулийн Зургаадугаар бүлгийн 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх заалт /Өөрийн хүсэлтээр/ |